

Лу “Алтан товч”-ийг “МНТ”-той харьцуулсан  
хэлний судалгааны нэг тал

Ш.Чоймаа (Монгол)

“XIII зууны дурсгал “Нууц товчоо”-ны олонх зүйл хожуу үеийн сурвалж бичиг “Алтан товч”-д хэрхэн бөөнөөрөө орж хадгалагдсан тухай асуудал бол маш сонирхолтой зүйл мөн бөгөөд энэ талаар эрдэмтэд янз бүрийн санал гаргаж иржээ. Зөвхөн нэг нэлээд ул үндэстэй саналын тухай өгүүлэхэд, Америкийн монголч эрдэмтэн Ф.Загчидцэцэн “Нууц товчоо” ба “Алтан товч”-ийг харьцуулан судалж, тус “Алтан товч”-д байгаа “Нууц товчоо”-ны бүх зүйл бол хятад үсгээр галиглан бичсэн “Нууц товчоо”-ноос буулган бичсэн гэдэг таамаглалыг няцааж, харин “Алтан товч” бол уул нь уйгуржин монгол үсгээр бичигдсэн “Нууц товчоо”-г ашигласан болно гэдэг дүгнэлтийг дэвшүүлжээ. Үүнээс үзэхэд, “Нууц товчоо” зохиогдсон цагаасаа хойш олны хүртээл болж чадалгүй “нууцлагдан” үлдсэн бус, харин сүүлийн үеийг хүртэл монгол түмний дотор аман уламжлалаар бус, монгол бичгээрээ ч үе улиран дамжиж ирсэн нь тодорхой”<sup>1</sup> хэмээн академич Ш.Бира 1990 онд фото зургийн аргаар хэвлүүлсэн Лу “Алтан товч”-ийн жинхэнэ эхийн оршилд бичжээ.

Өдгөө монголч эрдэмтэд “МНТ”-ны эх зохиол нь уйгуржин монгол бичгээр байсан гэдэгт нэгэнт эргэлзэхээ больжээ. Лу “Алтан товч”-ийн “МНТ”-той тохирох хэсгүүдийг агуулгын хувьд судалснаас бус хэлбичгийн талаас нь нарийвчлан шинжилсэн судалгаа үгүйлэгдэж байна. Оросын монголч эрдэмтэн М.Н.Орловская 1984 онд “Алтан товчийн хэл” гэсэн сонирхолтой судалгааны бүтээл хэвлүүлсэн юм. Гэвч түүний зорилго, номын агуулга нь “Алтан товч”-ийн хэлний хэлзүйн онцлогийг, орчин цагийн монгол хэлтэй харьцуулж гаргах анхны оролдлого байсан билээ<sup>2</sup>.

Лу “Алтан товч”-ийн хэлийг бүхэлд нь нэг цогц болгон судлах нь төдийлөн оновчтой бус юм. Учир нь Лу “Алтан товч”-ийн гол цөм агуулгыг

<sup>1</sup> “Алтан товч” (Лувсанданзаны “Алтан товч”-ийн эх бичгийн хуулбар), Улаанбаатар, 1990.

<sup>2</sup> М.Н. Орловская, “Язык “Алтан товчи”, Москва, 1984, стр. 3.

бүрдүүлж байгаа сурвалжууд бол XIII зууны гайхамшигт дурсгал "МНТ" болон ХҮИ зууны эхэн үеийн сурвалж "Хураангуй алтан товч" хоёр бөлгөө. Ийнхүү хэдэн зуунаар алслагдсан хоёр сурвалж бичгийн үг хэллэг, хэлзүйн хэлбэрийг бараг өөрчлөлгүй ашигласан тул Лу "Алтан товч"-ийн хэлийг судлахдаа тухай тухайн үеийн сурвалж бичигтэй харьцуулах нь илүү оновчтой юм.

Лу "Алтан товч"-ийг "МНТ"-той хэлний талаар харьцуулан судлахын тулд ХҮИ зууны түүхч Лувсанданзанд чухам ямархуу онцлогтой "МНТ"-ны эх байсан бэ? гэдгийг эрхбиш тодруулах учиртай.

Нэрт монголч эрдэмтэн Л.Лигети бээр "ХҮИ зууны түүхчийн гарт "МНТ"-ны онцлог нэгэн хувилбар байжээ"<sup>3</sup> гэж тэмдэглэсэн байдаг. Чухам ямар онцлогтой хувилбар эх байсан бэ гэдгийг өгүүлэхэд олон талын судалгаа шаардах бөгөөд жич судлан бичих асуудал юм. Гэвч өөрийн бодлыг товчлон өгүүлбэл, агуулгын хувьд өдгөө бидэнд уламжлан ирсэн "МНТ"-ны 1-дүгээр зүйлээс 268-дугаар зүйл дуустал буюу Чингис хааны дээд өвөг Бөртэ Чоноос эхлэн Чингис хааныг тэнгэрт халих хүртэл үеийг хамарсан нэгэн эртний хувилбар байсан болов уу гэж санана. Магадгүй, түүний нэр нь "cinggis-qahan-nu huja'ur" ["Чингис хааны язгуур"] хэмээсэн байж болох юм. Тийн үзэхийн хэд хэдэн учир шалтгаан буйг энд нуршин үл өгүүлнэ.

Үсэгзүй, бичвэрийн онцлог гэвэл; үсгийн махбод, түүний зурлага, бичгийн хэв хэлбэр нь сонгодог бичгийн өмнөх үеийн уйгуржин монгол бичгийн дурсгалуудтай адил байсан гэж үзэж болох буй. Энэ нь зөвхөн зохиогдсон цаг хугацаагаар нь тааруулж байгаа хэрэг бус бөгөөд Лу "Алтан товч"-д алдаатай бичсэн үгс болон хэдэн янз бичсэн нэг үгийн бичлэг зэргийг "МНТ"-ны галиг эхтэй харьцуулан үзвэл ийм дүгнэлтэд хүрэх юм.

Үгийн эхний "s" ( ᠰ ), "q" ( ᠴ ) бараг адил дүр төрхтэй байсан тул Лувсанданзан болоод "МНТ"-ыг монгол хэлээр хятад үсгээр галиглагчийн аль аль нь андуурсан зүйл олон байна. Үүгээр мөшгиж, нэлээд үгийн алдаа мэдгийг залруулан уншиж болох ажээ.

Үгийн төгсгөлийн дэвсгэр "s" үсгийг уг эхэд богино сүүлээр бичсэн байсан бөгөөд заримдаа уртхан татсанаас үүдэж, үгийн төгсгөлийн дэвсгэр "n" үсэгтэй эндүүрэгдсэн жишээ цөөнгүй тохиолдоно. Мөн уг эхэд цэг дусал тавиагүй бөгөөд шүд, шилбэ хоёрыг ялгах ааргүй бичсэн газар ч байсан бололтой. Түүнчлэн үгийн төгсгөлийн "i" ( ᠶ ) "r" ( ᠷ ) үсгийг эндүүрсэн зүйл олон байх бөгөөд Лувсанданзанд тун "өвгөрсөн" элж хуучирсан судар байжээ гэдгийг онцолж тэмдэглэх ётой.

Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалд цөөнгүй тохиолддог үгийн эхний "e" ( ᠡ ) үсгийг титим шүд ( ᠡ ) хоёроор бичих онцлог "МНТ"-ны эх сударт мөн адил байжээ хэмээн үзэж болохоор жишээ баримт гарч байна.

"МНТ"-той харгуулан үг үсгээр нягтлан үзэхэд Лувсанданзан болон түүний бичээч нарын хайхрамжгүйгээс, ямар ч учир шалтгаангүй

<sup>3</sup> М.Н. Орловская, "Язык "Алтан тобчи", Москва, 1984, стр. 16.

орхиж гэсэн хэсэг бүлэг үгс цөөнгүй тохиолдох ажээ. Тэдгээр нь сайн анхааралгүй, мөр алгасан бичээд явчихсан байдалтай байх ба хамгийн сонин нь тэрхүү орхисон үгсийн тоо нь ойролцоо, өөрөөр хэлбэл судрын нэг мөр гэж хэлж болохоор байгаа юм.

Лу "Алтан товч"-д орхисон "МНТ"-ны дараах гурван хэсгийг харьцуулан ажиглая:

**МНТ §112:** "...belgütei-yin eke tere ayil-tur buyu ke en ja'aqdaju..."  
(R-46)\*

**МНТ §130:** "...jamuqa-daca qaqacaju tende cinggis-qahan-tur neyilen..." (R-55)

**МНТ §149:** "...irejü'üi ke'en cinggis-qahan bidan-i tus-iyān qardaju..."  
(R-68)

Лу "Алтан товч"-д гурван өөр газар орхисон дээрх гурван хэсэг үгсийн тоо, монгол бичгээр бичсэн байх баримжаа урт нь ойролцоо байх тул Лувсанданзанд байсан "МНТ"-ны эх судрын нэг хуудасны бичвэрийн мөрийн урт ийм хэмжээтэй байжээ хэмээн төсөөлж болмоор санагдана.

Харьцуулан үзэх явцад, "МНТ"-ны уг эхэд байсан үг өгүүлбэрийг "МНТ"-ыг хятадаар галиглагч бээр орхиж гээснийг Лу "Алтан товч"-оос нөхөн сэргээх бололцоо бас гарах ажээ.

XVII зууны түүхч Лувсанданзанд XIII зууны үед бичсэн жинхэнэ эх судар байгаагүй ч гэсэн эртний дүр төрхөөр нь хуулсан хувилбар эх байсан тул түүнийг зөв уншиж, ухаарч ойлгож бичнэ гэдэг XVII зууны бичгийн хүнд үнэхээр хүнд ажил байсныг эрхбиш бид бодолцох ёстой.

Лувсанданзан болон түүний бичээч нар эх сударт үнэнч хандсан хэдий ч тухайн үеийн хүмүүст уншиж ойлгох, ухааж мэдэхэд хялбар дөхөм болгохын тулд яах аргагүй засан найруулах шаардлага тулгарчээ. Тэгэхдээ, тэд өөрсдийн нутгийн аялгуунд суурилсан үг хэлний мэдлэг, XVII зууны бичгийн хэлээр л хэмжүүр болгон засаж найруулсан нь хэнд ч ойлгомжтой зүйл билээ.

Лувсанданзаны засварыг ерөнхийд нь гурав ангилж болно:

1. Үсэгзүйн хүрээнд хийсэн өөрчлөлт
2. Хэлзүйн хүрээнд хийсэн өөрчлөлт
  - 2.а. Үгзүйн хүрээнд хийсэн өөрчлөлт нь нэр, үйл үгийн нөхцөлийг сольсон, нэмсэн, хассан зэрэг болно.
  - 2.б. Өгүүлбэрзүйн хүрээнд хийсэн өөрчлөлт нь богино өгүүлбэрүүдийг нийлүүлсэн болон урт өгүүлбэрүүдийг задалж найруулсан, өгүүлбэрийн доторхи үгсийн байрыг сольсон зэрэг болно.
3. Үгийн сан, утгазүйн хүрээнд хийсэн өөрчлөлт

---

\* "МНТ"-ноос жишээ баримт эшлэхдээ "Igor de Rachewiltz, *"Index to the secret history of the mongols"*, Bloomington, 1972" номыг хэрэглэгдэхүүн болгов.

Энэ өгүүлэлд зөвхөн үгийн сан, утгазүйн хүрээнд ямар өөрчлөлт хийснийг тухайлан ярих болно.

XVII зууны үе гэхэд "МНТ"-ны эхийн олон үг хэллэг нэгэнт хуучирч, тухайн үеийн хэл ярианд хэрэглэгдэхгүй болж, зөвхөн их эртний судар ном, түүний дам хуулбарт л тохиолдох болжээ гэдгийг Лу "Алтан товч" тодорхой гэрчилж байна. Бид Лу "Алтан товч"-ийн "МНТ"-той тохирдог хэсгийг мөр зэрэгцүүлэн галиглаж, ялгаа зөрөөг эх бичиг судлалын үүднээс тайлбарлах ажил хийж байгаа бөгөөд Лувсанданзан болон түүний бичээч нарын оносон, алдсан бүгд нь тодорхой учир шалтгааныг агуулж байгааг тэмдэглэвэл зохилтой.

Лувсанданзан "МНТ"-ны уйгуржин монгол бичгээр бичсэн эхийн хувилбар хуулбарыг ашиглахдаа үгийн сан, утгазүйн хүрээнд хийсэн өөрчлөлтийг дараах хэдэн зүйлээр тоймлон өгүүлье.

### Нэг.

XVII зууны бичгийн хүнд үгийн утга нь бараг төлөв ойлгогдох боловч тухайн үеийн хэл ярианд хэрэглэгдэхгүй болсон хуучирсан үгсийг тэр цагийн хүмүүст ухахад дөхөм болгох зорилгоор солин өөрчилж, засан найруулжээ. Үүнд:

1.1. Хуучирсан дан үгийг утга тохирох идэвхтэй ганц үгээр сольж найруулсан тохиолдол цөөнгүй буй. Жишээ нь:

	МНТ <sup>+</sup>		ЛАТ <sup>++</sup>
§19	o'orba (R-16)	→	orkiba (6a)
§24	yorciju (R-17)	→	oduyad (7a)
§35	ha'uliyā (R-19)	→	dayuliy-a (8a)
§53	ö'esün (R-22)	→	öbesüben (10a)
§62	ayisulu'a (R-25)	→	irelüge (14a)
§63	[caqān singqor] ... tu'uba (R-25)	→	bayuba (14a)
§65	nuntuq (R-26)	→	nutuy (14b)
§66	cocimtawu (R-26)	→	čocimtayai (14b)
§69	mörölgü (R-27)	→	mörügedkü (15a)
§70	jirin (R-27)	→	qoyar (15b)
§74	temgüjü (R-28)	→	tegüjü (16b)
§74	kö'üt (R-28)	→	köbegüd (16b)
§76	buliju (R-29)	→	buliyaju (17a)

<sup>+</sup> "МНТ"-ноос жишээ баримт эшлэхдээ "Igor de Rachewiltz, *"Index to the secret history of the mongols"*, Bloomington, 1972" номыг хэрэглэгдэхүүн болгов.

<sup>++</sup> Лу "Алтан товч"-оос жишээ баримт эшлэхдээ 1990 онд фото зургийн аргаар хэвлүүлсэн жинхэнэ эхийг ашиглав. "Алтан товч" (Лувсанданзаны "Алтан товч"-ийн эх бичгийн хуулбар), Улаанбаатар, 1990.

§79	ungsiju [ügüлерүн] (R-30)	→	dayudaju [ügüler-ün] (18b)
§80	kituqai (R-31)	→	kituy-a (18b)
§83	kelele (R-32)	→	ügüle (19b)
§84	ani (R-32)	→	teden-i (19b)
§85	esüg (R-33)	→	ösüg (20a)
§87	nambuqa (R-34)	→	namuy-a (20b)
§90	mungtaniju (R-35)	→	mengdejü (21a)
§97	nelkei (R-38)	→	öligei (23b)
§100	haran (R-39)	→	arad (24a)
§102	[geyit-tür-iyen] ajiraba (R-40)	→	[ger-tür-iyen] qariba (24b)
§103	qarca (R-40)	→	qariyaçi [qariyaçai] (25a)
§105	kö'ürge (R-42)	→	kenggerge (26b)
§109	görö'ülücün (R-44)	→	görügeçin (28a)
§110	[teberildün] tusulcaba (R-45)	→	[teberildün] jolyaldubai (28a)
§116	[quraltuq] si'a (R-47)	→	[γuraltuy] šayai (30a)
§118	asaqsu (R-49)	→	asayuy-a (30b)
§118	uyidangqa (R-49)	→	uyidumuqai (30b)
§127	ba [qoyar] (R-53)	→	bida [qoyar] (34b)
§131	[büri-bökö tere gü'ü-ben] hoyimascu (R-55)	→	[büri-böke tere qulayayiçi-ban] ömügüren (36a)
§145	talju (R-63)	→	tayilju (42b)
§145	cinana (R-63)	→	çiyān-a (42b)
§145	amduriju (R-64)	→	mendürüjü (43a)
§145	[amin minu] sengtelba (R-65)	→	[amin-iminu] jaljabai (43b)
§156	sewürelbi (R-73)	→	següresülebe (56a)
§163	ihe'el (R-76)	→	ibegel (58a)
§165	andur (R-77)	→	teden-tür (58b)
§165	anu [uruq] (R-77)	→	teden-ü [uruγ] (58b)
§170	[naran] kebeli'ülün (R-81)	→	[naran] kelbei-ülüged (61a)
§172	[mör] mütkin (R-84)	→	[mör-iyer] mösgin (63b)
§228	qadanadus (R-131)	→	γadayadu (74a)
§229	[kebte'ül-e] ta'ulju (R-132)	→	[kebtægül-e] dayalyaju (74a)
§229	qadärtu-yi (R-132)	→	qajayar-tu-yi (74b)

Энд жишээ болгон дурдсан үгсийг Лу "Алтан товч"-д гарах бүх тохиолдолд тэр мэт сольж найруулсан хэмээн үзэж болохгүй бөгөөд үг бүрийн тухай дахь байдал нь адил бус юм. Зарим жишээг дурдахад, дундад үеийн монгол хэлэнд эм хүйст хүний хос бүхийг заахад "jigin" гэдэг үг түгээмэл хэрэглэдэг байсныг "МНТ"-ны хэл нуталдаг бөгөөд уг үгийг Лу "Алтан товч"-д тохиолдох бүрд "qoyar" гэдэг үгээр сольж бичжээ. Орчин цагийн монгол хэлний "булаах" гэдэг үг эртний болон дундад үеийн монгол хэлэнд "buliqu" (булих) гэж байсан бөгөөд Лу "Алтан товч" "МНТ" хоёрын тохирох хэсгүүдэд нийт 9 удаа тохиолдсоноос гуравт нь "МНТ"-ны эхийг баримтлан "buliqu" гэж бичээд, бусад зургаан тохиолдолд "buliyaqu" хэмээн өдгөөчилж найруулсан байх ажээ.

Мөн түүнчлэн, дундад үеийн монгол хэлэнд тун идэвхтэй хэрэглэгдэж байсан "haran" гэдэг үг XVII зууны үе болоход нэгэнт хуучирч энгийн хүн байтугай бичгийн хүмүүст ч сайн ухагдахгүй болсныг Лу "Алтан товч" гэрчилж байна. "haran" гэдэг үг "МНТ"-нд 46 удаа тохиолддог бөгөөд үүнээс "МНТ"-ны Лу "Алтан товч"-той тохирох хэсгүүдэд 33 удаа гарах ёстойг бүртгэн харгуулж үзвэл, "aran" гэсэн эх бичгийн хэлбэрээр 18 удаа, "arad" болгож сольсон тохиолдол 8, "kümün", "nöküd" гэсэн үгээр хальж найруулсан нь нэг нэг, орхиж найруулсан газар хоёр, "агу-а" гэж ташаа уншиж бичсэн нэг тохиолдол буй. Энэ үгийг Лувсанданзан болон түүний бичээч нар эхэн хэсэгтээ сайн ойлгохгүй зөвхөн хамбичвэр (контекст)-ээс нь ухаж байгаад олон дахин гарсны хойно "aran" гэсэн хэлбэрээр нь бичиж эхэлсэн байх юм.

"haran" гэдэг үгтэй холбогдуулан нэгэн зүйлийг тэмдэглэхэд, XIII зууны монгол хэлний дурсгалуудад "arad" гэсэн хэлбэр ер тохиолддоггүй бөгөөд харин "haran" гэдгийн "-н" залгавар нь дундад үеийн монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгдэж байсан олон тооны нөхцөл "-н" мөн бололтой байдаг. Үүнийг "МНТ"-ны хэлний баримт нутлах бөгөөд нэгэн жишээ татахад, 149-дүгээр зүйлд "...tus [qan]-iyan qardaju irekset ya'un itegelten haran ede bidan-tur basa ker nököcekün nököcel üge'ün haran tus qan-iyan qardaqsat haran-i mököri'üldekün..." (R-68) хэмээснийг ажиглахад, дундад үеийн монгол хэлний тодотгогч, тодотгуулагч нь олон тоогоор зохицдог ёс жамын дагуу "haran" гэдэг үг олон тоот утгатай нь тод харагдаж буй. Энэ байдал мөн дөрвөлжин бичгээр буй монгол хэлний дурсгалуудад адилхан ажиглагдана. Жишээлбэл: 1320 оны Дармабалын хатны зарлигт "...эднээ харьяатан аран, адуусан, газар усан, юуд хэдийг (ya'ud ked-i) ану бусад аран булиж (buliju) татаж бүү автугай..."<sup>4</sup> хэмээн байх ба энд "аран" (haran) гэдэг үг "хүмүүс" гэсэн утгаар байгаа нь илт мэдэгдэж байх буюу.

1.2. "МНТ"-ны холбоо, хоршоо үгийг тухайн үеийн хэл ярианд ойртуулан засаж, утга ойролцоо холбоо хоршоо үгээр сольж найруулсан жишээ цөөнгүй тохиолдоно.

	МНТ		ЛАТ
§11	uruq-a ülü bolqan (R-14)	→	uruy-a ülü toyan (5b)
§13	...miqa gübcin-i (R-15)	→	bügüde miqan-i (5b)
§19	...niji'el müsüt (R-16)	→	nijiged mösün (6a)
§19	...ququciju o'orba (R-16)	→	quyulju orkiba (6a)
§21	qara teri'ütü gü'ün-tür qanilqan (R-16)	→	qaraču kümün-tür qanidqan (6b)
§31	qorumut gülice (R-18)	→	qorumqan küliy-e (7b)
§65	ökin kö'ün (R-25)	→	ökin uruy (14b)
§75	cilüme gubci'ur (R-29)	→	gölmi yubci'ur (17a)
§78	kö'üd-iyen gelin [anggir] (R-30)	→	juljayan-iyan gelin (18a)

<sup>4</sup> jāyunnasutu, "bá sái bá zì hè měng gu yu wen xiàn", II wen xiàn hui jì, ("Пагва үсэг хийгээд монгол хэлний дурсгалууд", II дурсгал бичгийн эмхтгэл) Tokyo, 1991, 116-р тал.

§78	siqaqu cinō (R-30)	→	dobtulqu činu-a (18a)
§86	iseri-yin dōro gūrtele (R-34)	→	iseri-yin alam-tur (20a)
§89	tarbaqat küčügür (R-34)	→	tarbay-a güčügün-e (20b)
§93	ke'ere buquqsan (R-36)	→	kegere talbiysan (22a)
§102	geyit-tür-iyen ajiraba(R-40)	→	ger-tür-iyen qariba (24b)
§103	saculi öci'üli ö[k]ba (R-40)	→	öčin sačuli sačuba (25a)
§114	usun-u buluqan jalqaqsan de'eltü (R-47)	→	usun-u qaliyun qaliyuluysan degeltü (29b)
§139	a'urtan sölsütan (R-60)	→	aýurtan killing-ten (39b)
§146	jarbiyal mudun-i (R-65)	→	jerge-yin modun-i (44a)
§150	sayi-bar el alduqsan-tur (R-69)	→	sayitur qaniluysan-tur (53a)
§214	muqular qara hüker (R-123)	→	muýuljar qara üker (68b)
§214	nökö'e kilgün bolun (R-124)	→	nögüge jīgür bolun (68b)
§214	aldal alda'asu (R-124)	→	endel endebesü (69a)
§260	naran singgegü-ece urququ-da gūrtele (R-156)	→	naran singgeküy-e iruýar-tur kūrtele (117a)

Өмнөх жишээ үгсийн нэгийг учирлан тайлбарлавал, “МНТ”-ны “naran singgegü-ece urququ-da gūrtele” [наран шингэхээс ургахад хүртэл] гэсэн холбоо үг Лувсанданзанд логик буюу учирзүйн үүднээс ер тохирохгүй санагдсан тул “naran singgeküy-e iruýar-tur kūrtele” [наран шингэхүйеэ ёроолд хүртэл] гэж найруулжээ. Үнэхээр “нар ургахуйгаас шингэхүй хүртэл” гэсэн тогтвортой холбоо үг эртний бичгийн дурсгалд цөөнгүй тохиолддог ба учирзүйн үүднээс ч зөв билээ. Харин “МНТ”-ны энэ хэсэгт яагаад ингэж өгүүлэв гэдгийг хамбичвэр (контекст)-ээс нь бодож үзэхэд, Чингис хаан баруун зүгийн дундад Азийн хот балгадыг эзлэн дайлж явах үед хааны гурван хорчийн айлтгасан үгэнд тус холбоо үг гарах бөгөөд утга нь энэ наран шингэх баруун зүгийн улс орнуудаас гадна наран ургах зүгт бид дайлан мордоогүй улс иргэн олон буй гэдгийг өгүүлсэн хэрэг бололтой.

Лувсанданзан энэ мэт учир зүйн дарааллыг бодож, зарим үг хэллэгийг найруулсан жишээний нэг нь “МНТ”-ны 103-дугаар зүйлд тохиолдоно. Тэнд “burqan-qaldun-i manaqar бүri maliyasuyai üdür бүri öcisügei” [бурхан халдуныг өглөө бүр мялаасугай, өдөр бүр өчсүгэй] хэмээсний “üdür” гэдгийг Лувсанданзан “üdesi” болгожээ. Чингэсний учир нь, тухайн үеийн шүтлэг, зан үйлийн зуршлаар өглөө, үдэш бүр газар усны эздэд идээ цагааныхаа дээжийг өргөдөг байсныг бодсон хэрэг юм. Одоо ч мөн адил ийм зан үйл бий билээ.

1.3. “МНТ”-ны нэг үгийг Лу “Алтан товч”-д хэдэн үгээр буюу үг нэмэн дэлгэрүүлж, тодотгон найруулсан зүйл нэлээд тааралдаж байна. Жишээ нь:

	МНТ		ЛАТ
§28	esükcilejü (R-17)	→	ösüg umdayan uuju (7a)
§40	kö'ülebi (R-19)	→	nuyun köbegün törübe (8a)

§59	a[b]ciraqsan-tur (R-24)	→	abču iregsen-tür (12b)
§74	teji'ebi (R-28)	→	söni edür nökcïyebei (16b)
§74	ja'uqasu-bar (R-28)	→	čadqasun tömesün-iyer (17a)
§76	qasi'u (R-29)	→	yasïyun berke (17b)
§81	jasajaju (R-31)	→	jasay ügüleldüjü (19a)
§81	kö'ün-ece (R-31)	→	keüked kümün-i (19a)
§81	buqa'u (R-31)	→	ginji bayu-bar-iyen (19a)
§85	sün [tüsürü'et] (R-33)	→	gegün-ü sün [tüsürügsen] (20a)
§87	tel qurigan (R-34)	→	tel eke-tü quray-a (20b)
§95	boro örmüge-ben böktürü'et (R-37)	→	boru örmegen jangčïn-iyen bögtürüged (22b)
§106	boljalduya (R-43)	→	boljayal tende boltuyai (27a)
§109	qokiratala [dauliba] (R-44)	→	qoyusun boltala [dayuliba] (27b)
§124	qonjijasun (R-52)	→	čayan miq-a (33b)

Энд зөвхөн Лувсанданзан бээр баттай үг нэмж найруулжээ гэж үзсэн үгсийн түүврээс цөөн жишээг эш татав. Лу "Алтан товч"-д байх боловч "МНТ"-нд үгүй бүх үгсийг Лувсанданзан болон бичээч нь нэмжээ гэж хэрхэвч үзэж болохгүй. Харин үүнийг судлан шинжилж, "МНТ"-ны жинхэнэ эхэд байсан эсэхийг магадлан тогтоох учиртай. Хамбичвэр (контекст)-ийн утга, учирзүйн (логик)-н үүднээс бодож үзвэл, "МНТ"-ны эхэд лав байсан гэж болмоор олон үг, өгүүлбэр Лу "Алтан товч"-д байдгаас ганц жишээ татвал, "МНТ"-ны 171-дүгээр зүйлд "...quildar-i unaqsan yaratu-yi abu'at..." (R-83) гэж байх ба Лу "Алтан товч"-д "...quyildar-i unaysan yaǰar-ača yaratu-yi abuyad..." (63a) гэж гарах бөгөөд "yaǰar-ača" гэдэг үг зайлшгүй байсан мэт. Үүнийг жичид нь судлах хэрэгтэй асуудал тул энд үл өгүүлнэ.

1.4. "МНТ"-ны эхийн хэдэн үгийг товчлон утгачилж, ганц үгээр сольж найруулан бичсэн жишээ тохиолдож байна. Жишээ нь:

	МНТ		ЛАТ
§22	söyü-'er üge (R-16)	→	suryal (6b)
§32	qataraju yorciju talbiba (R-18)	→	...qataribasü (7b)
§38	bodancar alginci ha'ulju... (R-19)	→	bodančar-i yaǰarčïlayulju (8a)
§38	...ke'en hasa[q]ba... (R-19)	→	...kemebesü (8a)
§65	...uduritcu bawulba (R-26)	→	...bayulyaba... (14b)
§99	...kötöl jasaba (R-38)	→	kötelbe (23b) гэх мэт.

1.5. Хүндэтгэлийн үг хэрэглэж, тухайн хэсэгт өгүүлэгдэж буй үйлийн эзнийг өргөн дээдлэхийн учир үгийн өнгө аясыг бодож сольж найруулсан зүйл бас таарах ажээ. Жишээ нь:

§46	nacin-ba'atur-un a[b]lin <u>eme-dece</u> töreksen (R-21) načïn bayatur-un abalin <u>gergei-eče</u> törügsen (9a)
-----	---

- §59 ...tende hö'elün üjin ke'elitei бүрүн... (R-24)  
 ...tende ögelen üjin köl kündü бүлүге... (12a)
- §67 yisügei –ba'atur... ger-tür-iyen гүрү'et mawui bolju... (R-26)  
 yisükei bayatur... ger-tür kürcü yekede älegerkebe... (15a)
- §125 ...basa cinggis-qahan ügülerün (R-53)  
 ...basa cinggis qayan jarliγ bolurun... (34a)
- §209 ...ede qubilai jelme jebe sübegetei  
 ...ede qubilai jelm-e sübegetei jebe  
 ta dörben noqas-iyen se[t]kixsen-tür jori'ulju...  
 ta dörben sutaqan-iyen sedkixsen-tür jaruju...  
 ...ta dörben noqas-iyen joriqsan qajar-a ilējü...(R-120)  
 ...ta dörben ünen-iyen jarixsan qajar-a ilegejü...(66a) гэх мэт.

Дээр иш татсан МНТ-ны 209-р зүйлд Чингис хааны дөрвөн хошууч баатрыг нохой гэж хэлэх ёсгүй гэж бодсон бололтой. Тийм учраас өөр үгээр сольж найруулсан бололтой. Мөн МНТ-ны 234-р зүйлд "...dödei-cerbi darun aju ordo-yin qoyinaca qoq idejü qoma'ul tülejü yabutuqai ke'en jarliq bolba..." (R-135) гэж гардаг. Чэрби цолтой, хааны соёрхол хүртсэн Дөдэй-г "хог идэж" яв гэж Чингис хаан зарлиг болов гэхэд үнэхээр үл зохилдоно. Лувсанданзан "qoγ abču" (хог авч) гэж бичсэн байх бөгөөд XVII зууны түүхч Жамба "qoγ qamuju" (хог хамж) гэж "Асрагч нэртийн түүх"-дээ бичсэн байдаг. "МНТ"-г хятадаар галиглагч бээр алдсан уу, эсвэл Лувсанданзан, Жамба нар эерүүлэн зөөлрүүлж бичсэн үү гэдгийг нягтлах зүйл юм.

"МНТ"-ны 134-р зүйлд "...cinggis-qahan-a ja'ut-quri nere ökba..." (R-57) гэж гардгийг Лу "Алтан товч"-д "cinggis qayan-a čay-un törü nere ögbe" (38a) гэж бичсэнийг энд хамаатуулан тайлбарлаж болох мэт. Лувсанданзанд "ja'ut-quri" гэдэг үг огт ойлгомжгүй бас бүдэг балархай, гаргаж унших боломжгүй байсан тул Чингис хаанд их л хүндэтгэлтэй үгээр нэр цол өгсөн биз гэж бодоод тийн бичсэн болов уу.

### Хоёр.

Тухайн үг хэллэгийг Лувсанданзан болон түүний бичээч нар мэдэхгүй байсан боловч хамбичвэр (контекст)-ийн утгаас нь ургуулан бодож, тийм болов уу гэсэн үгээрээ сольж найруулсан жишээ цөөнгүй тохиолдох ажээ. Тааж таамаглаж найруулсан учир яг таг оноосон үгээр сольж чадаагүй нь харьцуулан харахад мэдэгдэнэ. Тийм жишээ нь:

	МНТ	ЛАТ
§55	quburi <u>nambalis</u> (R-22)	<u>quburi alus</u> (10b)
§56	kiligü dergecejü (R-23)	<u>temegen gelijü</u> (11a)
§77	sumu-ban <u>salbaju</u> (R-29)	<u>sumu-ban solbiāju</u> (17b)
§85	tergen-tür <u>unu'ulju</u> (R-33)	<u>tergen-tür niγuju</u> (20a)
§90	ere-yin <u>munq</u> (R-35)	<u>ere-yin eril</u> (21a; 21b)
§103	merkid-i <u>küngke'ülijü</u> (R-40)	<u>merged-i kögelgejü</u> (25a)

§108	qojit bayiba ke'en <u>qodulaqu-yi</u> (R-44)	<i>qojid bolba kemen yutuylqu-yi</i> (27b)
§111	qotola merkit-e <u>huntawu</u> bolba (R-46)	<i>qotala merged-e buruyu bolba</i> (28b)
§112	mawui gü'ün-tür <u>tübejü</u> (R-46)	<i>mayu kümün-tür uĉaraĵu amu</i> (29a)
§116	anda <u>tunggulduju</u> amaralduya ke'eldüba(R-47)	<i>anda dongyuldun amuralduba</i> (29b)
§117	qurimlan <u>toyilan</u> jirqalduju (R-48)	<i>qurimlan dayilan jiryalduju (30a)</i>
§124	<u>silegü</u> irge šülen bolqaju (R-52)	<i>sineken irege silün bolĵaju (33b)</i>
§145	<u>bökleksen</u> cisun (R-64)	<i>bögelĵgsen äsun</i> (42b; 43a)
§165	<u>ala'un-a</u> bayiji (R-77)	<i>alus-a bayiju</i> (58b)
	<u>ala'un-a</u> qaran aju'u (R-77)	<i>alus-a qaran aĵuyu</i> (58b)
§166	teyin <u>dura</u> qocaruqsan-i (R-77)	<i>teyin dour-a qoĉuruqsan-i (59a)</i>
	ta ese <u>nende'esü</u> tan-a ya'u bolqu (R-78)	<i>ta ese uqabasu tan-a yaĵu bolqu</i> (59a)
§168	manaqar erte <u>bücijü</u> bariya (R-79)	<i>manaĵar erte bosĉu bariya (60b)</i>
§169	<u>qoš-dur-iyän</u> (R-80)	<i>qonin-tur-iyän oruju</i> (61a)
§170	to'oriqui tutum <u>toy</u> jokiyu (R-81)	<i>toĵuriqu tutum töb jokiqu (61b)</i>
§209	derge-de'en <u>a'asu</u> (R-120)	<i>derge-tegen abubasu</i> (66a)
§210	<u>gendü</u> cinö (R-121)	<i>görgügentü änu-a</i> (66b)
§212	öröle ji'ür bolun <u>jiktüldüjü</u> (R-121)	<i>öbere jigür bolun ĵogeldüĵü (67a)</i>
§219	aqa de'ü-de <u>nayitaju</u> bari'asu (R-125)	<i>aq-a degüü-te egerigdeĵü bariydabasu</i> (69b)
§230	oron dотора ese <u>oqjatqaqsan</u> (R-133)	<i>orun dotura ese untaysan (75a)</i>
§244	qasar-i ese <u>nende'esü</u> ...(R-140)	<i>qasar-i... ese medebesü (94b) гэх мэт.</i>

### Гурав.

Лувсанданзанд уламжлан ирсэн "МНТ"-ны эх нь эртний монгол бичгийн хэв хэлбэртэй бас бүдэг балархай байсан гэдгийг дээр олонтаа өгүүлсэн. Бас өгүүлэх ёстой нэгэн хэсэг үг бол уг үгийн утга нь мэдэгдэхгүй, бүдэг балархай тул эхэд бичсэн байдлыг дуурайлган төсөөлж, ургуулан бодож, ийм үг болов уу хэмээн сэргээн бичсэн зүйлс юм. Жишээ нь:

### МНТ

### ЛАТ

§77	ker <u>alduqun</u> [байхун] (R-29)	ker <u>aldaqun</u> [алдахун] (17a)
-----	------------------------------------	------------------------------------

§78	<u>borbi qajaqu bu'ur metü</u> (R-30)	<i>borqin qaǰaqu buγura metü</i> (18a)
§102	<u>emes-i anu abuba</u> (R-40)	<i>ami-γi anu... abubai</i> (24b)
§105	<u>qor darbaljaqui-tur</u> (R-42)	<i>qui dayibalǰuqui-tur</i> (26b)
§109	<u>dayin ayisi ke'en</u> (R-44)	<i>tere ǰsün yaman [ǰaman]</i> (28a)
§134	<u>tatar-i da'uliju</u> (R -57)	<i>tatar-i duliǰu</i> (38b)
§145	<u>suiyasu-ban silürtejü</u> (R-63)	<i>qubǰsun-ban silürtejü</i> (42a)
§170	<u>könggelen ya'u ke-ben gē'et</u> <u>burūilan</u> (R-81)	<i>könggelen keüked-iyen</i> <i>gegeged buruγuyilan</i> (61a)
§208	<u>jürcedei-yi algincilaju</u> (R-119)	<i>jürǰdei arqai qasar qoyar-i</i> <i>aminǰyulǰu</i> (65a)
§214	<u>siji'asu-ban sumun-a tusda'asu</u> (R-124)	<i>quyisiban sumun-a tusdǰǰu</i> (68b; 69a)
§230	<u>irgetei ger</u> (R-133)	<i>erüketei ger</i> (75a)
§235	<u>ese bulqaba</u> (R-135)	<i>ey-e bolγaldaba</i> (85b) гэх
	мэт.	

Энд тэмдэглэх нэгэн зүйл бол уг эхэд зарим үгийн үгсийн махбод тун балархай байсныг олон баримт нутлах бөгөөд жишээлбэл, эртний монгол хэлний "dauᠯiqu" гэдэг үгийн "d" үсгийн дараах "a" үсгийг тэмдэглэсэн шүд нь харагдахгүй байсан тул Лу "Алтан товч"-д "duliᠯiqu" гэж тэмдэглэсэн нь олонтаа тохиолдоно.

"МНТ"-ны нэгэн эхийг XVII зууны түүхч Лувсанданзан ашиглахдаа үгийн сан, утга зүйн хүрээнд ямархуу өөрчлөлт хийсэн бэ гэдгийг тоймлон өгүүлэв. Ингэж тусгайлан судалбал, монгол хэлний үгийн сан, түүний утга хэрхэн хувьсч өөрчлөгдөж ирснийг цөөн бус үг хэллэгийн хэмжээнд мэдэх боломжтой юм. Нөгөө талаар Лувсанданзан болон түүний бичээч нар аль нутгийн аялгуугаар ярьдаг, хир зэргийн бичгийн боловсролтой хүмүүс байж вэ гэдгийг ч ямар нэг хэмжээгээр тодруулж болох талтай. Ганц жишээ дурдахад, малын бүдүүн гэдсэнд мах, өөх зэргийг чихэж бэлдсэн улаан идээний нэгэн зүйлийг хос, хошгоног, гургалдай, гонж, цагаан мах гэх мэтээр нутаг нутагт янз янзаар нэрлэдэг бөгөөд уг үгийг "МНТ"-нд "qonǰi'asun" гэж бичсэнийг Лу "Алтан товч"-д "ᠰaγan miq-a" гэж сольж найруулсныг үзэхэд лав тэдний нутагт хосыг цагаан мах гэж хэлж ярьдаг байжээ.

Төгсгөлд тэмдэглэн хэлэхэд, "МНТ" болон Лу "Алтан товч" хоёрт адил бус бичлэгтэй нэлээд үгс байдгийг энд зориуд дурдаагүй бөгөөд түүнийг эл өгүүлэлд ажиглан шинжилсний нэгэн адил Лувсанданзан засан найруулсан мэтээр ойлгож болохгүйгээр үл барам харин "МНТ"-ыг хятад үсгээр галиглагчийн эндүүрэн будилж, эндэж алдсан зүйлийн зөв бичлэгийг Лу "Алтан товч"-ийн эхэд тулгуурлаж, хянан магадалж, нэхэн сэргээх боломжтой юм. Энэ нь харьцуулсан судалгааны жич нэг сэдэв болох билээ.

